АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хангай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2025/096/НА-СТА-ТШ3**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2026 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br><br>Аудитор С.Оргил<br>Утас: 77665858<br>Цахим хаяг: Info@shinjlenmagadlakhui-audit.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 74
танай ____________-ны №____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХАНГАЙ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Г.СҮРЭНХОРЛОО ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Хангай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,023,963.70 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,004,954.84 мянган төгрөгийг зарцуулж 19,008.86 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 үндсэн зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР                    Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **192,707,531.05** | **149,405,229.69** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 84,713,189.78 | 19,008,861.80 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 84,713,189.78 | 19,008,861.80 |
| **3121** | **Төгрөг** | 84,713,189.78 | 19,008,861.80 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 84,713,189.78 | 19,008,861.80 |
| **33** | **АВЛАГА** | - | 2,468,168.62 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 2,468,168.62 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 107,994,341.27 | 127,928,199.27 |
| **351** | **Түүхий эд материал** | 79,169,598.00 | 88,209,898.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 77,564,648.00 | 86,543,048.00 |
| 35130 | Эм боох материал | 1,604,950.00 | 1,666,850.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 28,824,743.27 | 39,718,301.27 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,842,574.00 | 9,114,174.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 20,015,378.00 | 29,452,428.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 825,000.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 141,791.27 | 1,151,699.27 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,164,502,385.71** | **1,149,817,405.93** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,164,502,385.71 | 1,149,817,405.93 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,146,902,385.71 | 1,132,217,405.93 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,172,510,000.00 | 1,172,510,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (105,599,783.16) | (126,777,536.88) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 70,548,328.00 | 70,582,498.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (27,581,930.60) | (17,650,208.42) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,516,519.87 | 18,466,992.23 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (16,148,348.36) | (2,618,338.96) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 27,006,754.00 | 25,636,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (7,349,154.04) | (7,932,000.04) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 17,600,000.00 | 17,600,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 17,600,000.00 | 17,600,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,357,209,916.76** | **1,299,222,635.62** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,164,502,385.71 | 1,149,817,405.93 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,146,902,385.71 | 1,132,217,405.93 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,172,510,000.00 | 1,172,510,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (105,599,783.16) | (126,777,536.88) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 70,548,328.00 | 70,582,498.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (27,581,930.60) | (17,650,208.42) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,516,519.87 | 18,466,992.23 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (16,148,348.36) | (2,618,338.96) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 27,006,754.00 | 25,636,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (7,349,154.04) | (7,932,000.04) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 17,600,000.00 | 17,600,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 17,600,000.00 | 17,600,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,357,209,916.76** | **1,299,222,635.62** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **1,690,400.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 1,690,400.00 |
| **413** | **Өглөг** | - | 1,690,400.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 1,690,400.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 1,690,400.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **981,381,774.12** | **1,297,532,235.62** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 981,381,774.12 | 1,297,532,235.62 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | - | 375,828,142.64 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 981,381,774.12 | 921,704,092.98 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 981,381,774.12 | 981,381,774.12 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (59,677,681.14) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **981,381,774.12** | **1,299,222,635.62** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **895,001,700.00** | **968,649,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **29,910,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 29,910,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 29,910,500.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | | 12,203,500.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө | | 17,707,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **895,001,700.00** | **938,738,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 841,487,600.00 | 856,599,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 841,487,600.00 | 856,599,100.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 53,514,100.00 | 82,139,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 53,514,100.00 | 82,139,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **834,328,107.79** | **1,028,326,881.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **834,328,107.79** | **1,028,326,881.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 826,607,296.79 | 1,022,223,940.14 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 612,770,958.72 | 741,458,448.69 |
| 210101 | Үндсэн цалин | 370,798,891.70 | 459,004,241.84 |
| 210102 | Нэмэгдэл | 209,204,767.02 | 242,283,166.85 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 18,145,000.00 |
| 210104 | Урамшуулал | 32,767,300.00 | 22,026,040.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 76,954,700.00 | 92,677,100.67 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52,329,200.00 | 63,001,087.67 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,156,400.00 | 7,131,762.46 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,078,200.00 | 5,883,302.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,078,200.00 | 3,220,137.55 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,312,700.00 | 13,440,810.64 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48,787,649.00 | 74,895,059.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,078,889.00 | 18,289,159.00 |
| 210302 | Түлш, халаалт | 38,092,500.00 | 54,542,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 616,260.00 | 2,063,400.00 |
| **2105** | **Норматив зардал** | 55,853,099.90 | 56,283,462.00 |
| 210502 | Хоол, хүнс | 55,853,099.90 | 56,283,462.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 506,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 506,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,140,000.00 | 2,573,670.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,140,000.00 | 2,573,670.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 31,100,889.17 | 53,830,199.78 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,026,630.00 | 16,998,320.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,334,400.00 | 4,439,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 7,739,859.17 | 32,391,979.78 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,720,811.00 | 6,102,941.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,203,100.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,203,100.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 517,711.00 | 6,102,941.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 517,711.00 | 6,102,941.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **60,673,592.21** | **(59,677,681.14)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **60,673,592.21** | **(59,677,681.14)** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 895001700 | 938738700 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 895001700 | 938738700 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 841487600 | 856599100 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 841487600 | 856599100 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 53514100 | 82139600 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 53514100 | 82139600 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 856752008.7 | 1004443028 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 856752008.7 | 1004443028 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 849031197.7 | 998340087 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 612770958.7 | 747481118 |
| 210101 | Үндсэн цалин | 370798891.7 | 457853751.4 |
| 210102 | Нэмэгдэл | 209204767 | 244799276.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0 | 18125000 |
| 210104 | Урамшуулал | 32767300 | 26703090 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 76954700 | 89122600 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52329200 | 60607500 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6156400 | 7130700 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3078200 | 3566200 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3078200 | 3566200 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12312700 | 14252000 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 50996389 | 74036659 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12796389 | 18289159 |
| 210302 | Түлш, халаалт | 36200000 | 53717500 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2000000 | 2030000 |
| 2105 | Норматив зардал | 53194290 | 57293370 |
| 210502 | Хоол, хүнс | 53194290 | 57293370 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2000000 | 2000000 |
| 210604 | Урсгал засвар | 2000000 | 2000000 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1590000 | 2573670 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1590000 | 2573670 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 51524860 | 25832670 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44321760 | 19966470 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7203100 | 5866200 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7720811 | 6102941 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 7203100 | 0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7203100 | 0 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 517711 | 6102941 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 517711 | 6102941 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 38249691.28 | -65704327.98 |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 4234640 | 0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 4234640 | 0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 4234640 | 0 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4234640 | 0 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -4234640 | 0 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 34015051.28 | -65704327.98 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 84713189.78 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 84713189.78 | 19008861.8 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 375,828,142.64 | - | 75,285,682.07 | 451,113,824.71 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **375,828,142.64** | **-** | **75,285,682.07** | 451,113,824.71 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 906,096,092.05 | 906,096,092.05 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **375,828,142.64** | **-** | **981,381,774.12** | 1,357,209,916.76 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **375,828,142.64** | **-** | **981,381,774.12** | 1,357,209,916.76 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **375,828,142.64** | **-** | **981,381,774.12** | 1,357,209,916.76 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (59,677,681.14) | (59,677,681.14) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **375,828,142.64** | **-** | **921,704,092.98** | 1,297,532,235.62 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО | 944,889,900.00 | 944,841,614.00 | 48,286.00 | 99.99 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 862,750,300.00 | 856,599,100.00 | 6,151,200.00 | 99.29 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 862,750,300.00 | 856,599,100.00 | 6,151,200.00 | 99.29 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 82,139,600.00 | 88,242,514.00 | -6,102,914.00 | 107.43 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 82,139,600.00 | 88,242,514.00 | -6,102,914.00 | 107.43 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 78,455,200.00 | | 78,455,200.00 | |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 78,455,200.00 | | 78,455,200.00 | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | **1,023,345,100.00** | **944,841,614.00** | **78,503,486.00** | 92.33 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,023,345,200.00 | 998,340,113.98 | 25,005,086.02 | 97.56 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,023,345,200.00 | 998,340,086.98 | 25,005,113.02 | 97.56 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 753,102,800.00 | 747,481,117.98 | 5,621,682.02 | 99.25 |
| 210101 | Үндсэн цалин | 483,489,100.00 | 457,853,751.43 | 25,635,348.57 | 94.7 |
| 210102 | Нэмэгдэл | 251,028,200.00 | 244,799,276.55 | 6,228,923.45 | 97.52 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 18,125,000.00 | -18,125,000.00 | |
| 210104 | Урамшуулал | 18,585,500.00 | 26,703,090.00 | -8,117,590.00 | 143.68 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 93,155,900.00 | 89,122,600.00 | 4,033,300.00 | 95.67 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,031,800.00 | 60,607,500.00 | 2,424,300.00 | 96.15 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,531,100.00 | 7,130,700.00 | 400,400.00 | 94.68 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,765,500.00 | 3,566,200.00 | 199,300.00 | 94.71 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,765,500.00 | 3,566,200.00 | 199,300.00 | 94.71 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,062,000.00 | 14,252,000.00 | 810,000.00 | 94.62 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 80,139,600.00 | 74,036,659.00 | 6,102,941.00 | 92.38 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,688,300.00 | 18,289,159.00 | 2,399,141.00 | 88.4 |
| 210302 | Түлш, халаалт | 57,451,300.00 | 53,717,500.00 | 3,733,800.00 | 93.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,000,000.00 | 2,030,000.00 | -30,000.00 | 101.5 |
| 2105 | Нормативт зардал | 65,976,300.00 | 57,293,370.00 | 8,682,930.00 | 86.84 |
| 210502 | Хоол, хүнс | 65,976,300.00 | 57,293,370.00 | 8,682,930.00 | 86.84 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 | | 100 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 2,000,000.00 | | 100 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,066,800.00 | 2,573,670.00 | 493,130.00 | 83.92 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,066,800.00 | 2,573,670.00 | 493,130.00 | 83.92 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,903,800.00 | 25,832,670.00 | 71,130.00 | 99.73 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,037,500.00 | 19,966,470.00 | 71,030.00 | 99.65 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,866,300.00 | 5,866,200.00 | 100 | 100 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | **1,023,345,200.00** | **1,010,545,941.98** | **12,799,258.02** | **98.75** |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 84,713,189.78 | -84,713,189.78 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 19,008,861.80 | -19,008,861.80 | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] илрээгүй, залруулаагүй 4,005.2 мянган төгрөгийн зөрчил[2] илэрч 2 албан шаардлага хүргүүллээ.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг зөрчил нь 4,005.2 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 11,512.6 мянган төгрөгөөс бага байгаа тул “**Өөрчлөлтгүй” дүгнэлт** өглөө.

### 3.1 Албан шаардлага

### 3.1.1. Худалдан авалттай холбоотой:

**<u>Илрүүлэлт:</u>** Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,537.0 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс аваагүй, бусад этгээдээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ", 38 дугаар зүйлийн 38.1-т "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна" гэж заасныг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### 3.1.2 Авлагатай холбоотой:

***<u>Илрүүлэлт:</u>*** Тайлант оны жилийн эцсийн тайлангаар нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварын тооцооллын зөрүүтэй холбоотой 2,468.2 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 -т 'эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр, дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах' гэсэн заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цахим худалдан авалттай холбоотой | 1 | 1,537.0 | | | 1 | 1,537.0 | | | | | | |
| Авлага үүссэн | 1 | 2,468.2 | | | 1 | 2,468.2 | | - | | | | |
| **Дүн** | **2** | **4,005.2** | | | **2** | **4,005.2** | **-** | **-** | | | | |